ВИДЕО МЭДЭЭ · 2022 оны 9-р сарын 9

Про подкаст №93 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЬЕ!



УЕПГ-ын Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн Б.Будхүү Увс аймгийн прокурорын газрын хяналтын прокурор С.Баярчимэгтэй "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлөөс урьдчилан сэргийлье!" сэдвээр ярилцлаа.

• Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс бие биеийнхээ сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг "Гэр бүлийн хүчирхийлэл гэнэ.

• Гэр бүлийн хүчирхийллийг харж байгаа хүүхэд бүр хохирогч болдог.

• Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн бол албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулдаг бөгөөд энэ үйлдлээ 3 болон түүнээс дээш удаа үйлдсэн тохиолдолд Эрүүгийн хуулиар 2 жил хүртэлх хугацаагаар хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэнэ.

• Хүн бүр гэр бүлийн зохистой харилцааг эрхэмлэх, бие биедээ хүндэтгэлтэй соёлтой харьцах, архи, согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэхгүй байх, мөн хүчирхийллийн хохирогч хүчирхийллийг даамжруулахгүйгээр мэдээлэх шаардлагатай.

Видео: https://www.youtube.com/watch?v=xyzqJy04KU8

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1923